

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд орших “Бор-Өндөр” УБҮ-ийн усны нөөц, ус ашиглалтын тайлан (усны аудит) хийлгэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Бор-Өндөр” УБҮ-ийн усны алдагдал болон ус хэмнэх нөхцөлийг тогтоож, түүнд шаардагдах хөрөнгийг тооцох, усны хэрэглээнд үнэлгээ өгөн, Монгол Улсын Усны тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны тухай хууль болон бусад холбогдох хууль, журамд нийцүүлэн тайлан боловсруулж, Захиалагчтай зөвшилцсөний эцэст эцсийн тайлан батлуулах болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар,
- Шүүхийн тодорхойлолт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт,
- Усны аудит хийх эрх бүхийг батлах тусгай зөвшөөрлийн хуулбар,
- Тендерт оролцогч Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар хураамж, төлбөрийн өргүй байх зэрэг болно.

Дээрх баримтууд нь эх хувиараа байх, хэрэв хуулбар хувь бол заавал нотариатаар баталгаажуулсан байх шаардлагатай бөгөөд бүх материалыг pdf файлын хэлбэрт шилжүүлэн тод гаргацтай харагдахаар цахимаар ирүүлнэ.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2019 оны 05 дугаар сарын 02–ны өдрийн 17<sup>00</sup> цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2019 оны 05 дугаар сарын 07 –ны өдрийн 10<sup>00</sup> цагаас өмнө дор дурдсан хаягаар ирүүлнэ үү.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

МОНГОЛРОСЦВЕТМЕТ ТӨҮГ